



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 10 сарын 05 өдөр

Дугаар А/329

Хэрлэн сум

Журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Авто замын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3, 30 дугаар зүйлийн 30.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хэнтий аймгийн орон нутгийн чанартай авто зам, замын байгууламжийг барих, засварлах, арчлах, хамгаалах, тохижуулах ажлыг сайжруулах зорилгоор "Орон нутгийн чанартай авто зам, замын байгууламжаар зорчиж буй тээврийн хэрэгслээс зам ашигласны төлбөр авах журам"-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймгийн Авто тээврийн төвийн дарга /Б.Ганбат/-д, хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Э.Мөнх-Эрдэнэ/-д, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/-д тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

**ОРОН НУТГИЙН ЧАНАРТАЙ АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖААР
ЗОРЧИЖ БУЙ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛЭЭС ЗАМ АШИГЛАСНЫ
ТӨЛБӨР АВАХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Журмын зорилго нь: Хэнтий аймгийн орон нутгийн чанартай авто зам болон Чингис хот доторх зам, замын байгууламжаар зорчиж буй тээврийн хэрэгслээс зам ашигласны төлбөр авахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Хоёр.Төлбөр авах үйл ажиллагаа

2.1. Хэнтий аймгийн орон нутгийн чанартай авто зам болон Чингис хот доторх зам, замын байгууламжаар зорчиж буй тээврийн хэрэгслээс зам ашигласны төлбөр авах, төлбөрийг орон нутгийн замын санд төвлөрүүлэх ажлыг аймгийн Авто тээврийн төв зохион байгуулж хэрэгжүүлнэ.

2.2 Орон нутгийн чанартай авто зам болон Чингис хот доторх зам, замын байгууламжаар зорчиж буй 1 тээврийн хэрэгслээс дараах ангиллаар зам ашигласны төлбөр авна. Үүнд:

2.2.1. Хэнтий аймгийн улсын бүртгэл /дугаар/-тэй тээврийн хэрэгслээс орон нутгийн чанартай авто зам, замын байгууламж ашигласны төлбөрийг жилд нэг удаа авто тээврийн улсын үзлэгийн үед тогтоосон хэмжээгээр авч гэрчилгээ олгоно.

2.2.2. Хэнтий аймгаас бусад аймаг, хотын улсын бүртгэл /дугаар/-тэй тээврийн хэрэгслээс орон нутгийн чанартай авто зам, замын байгууламж ашигласны төлбөрийг төлбөр авах цэгүүдээр нэвтрэх тухай бүрд тогтоосон хэмжээгээр авч тасалбар олгоно.

2.2.6 Тээврийн хэрэгслийн жолооч нарт олгох гэрчилгээ болон тасалбарын загварыг аймгийн Авто тээврийн төвийн даргын шийдвэрээр батлан хэвлүүлж аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсээр баталгаажуулж, үнэт цаасны тооцоог хянуулна.